БАТЛАВ
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.ЗОРИГТБАЯР

“ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГТ СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ЛАНДФИЛЛ БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСВИЙГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 12 сарын 10-ны өдөр Баян-Өндөр сум

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Аймгийн ИТХ-ын 2025 оны ээлжит V хуралдааны 02/58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт”-н 2.3.2 дахь заалт.
2	Байршил	Орхон аймаг, Баян-Өндөр сумын хог хаягдлын нэгдсэн цэгт
3	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал	*“Хог хаягдлын төвлөрсөн цэгт стандартын шаардлага хангасан ландфилл байгуулах ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх”* Орхон аймгийн Баян-Өндөр сум, Эрдэнэт хотын 29400 өрхийн 103130 хүн ам, 2690 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг дарж, булшлах хүчин чадалтай, нэгдүгээр зэрэглэлийн хогийн цэгт тавигдах стандартын шаардлага хангасан, зориулалтын ландфилл байгуулах зураг, төсвийг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийн дагуу орон нутгийн онцлогт тохируулан гаргаж, баталгаажуулсан байна.
4	Дагаж, мөрдөх ерөнхий төлөвлөгөө	Баян-Өндөр сум, Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.
5	Эдэлбэр газар	Аймгийн Засаг даргын 2000 оны 4 сарын 24-ийн өдрийн А/134 -р газар эзэмшүүлэх захирамж /эзэмших талбай 80.3 га/
6	Барилгажих талбай /төлөвлөлтийн талбайгаар/	- Орон нутгийн мэргэжлийн байгууллага болон, ашиглагч байгууллагын саналыг үндэслэн газар дээр нь хэмжилт хийж тогтоох. - Ландфиллын байгууламжийн хэмжээ, хүчин чадал, бүрэлдэхүүнд байгаа бусад барилга, байгууламжийн хэмжээг барилгажих талбайтай уялдуулан мэргэжлийн байгууллагаас гаргуулан авч, зурагт тусгах.
7	Төвлөрсөн хогийн цэгийн байгууламжийн бүрэлдэхүүн	Нэгдүгээр зэрэглэлийн ландфиллын байгууламж байх ба дараах шаардлагыг хангасан байна. 1. Зураг, төсвийг стандартын дагуу боловсруулсан байх; 2. Шүүрлийг цуглуулах, хуримтлуулах, цэвэршүүлэх системтэй;

		3. Хог хаягдлын ялзралаас үүсэх хийг зайлуулах, хуримтлуулах системтэй; 4. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооногтой; 5. Үерийн хамгаалалтын далан, хур борооны ус зайлуулах системтэй; 6. Хог хаягдлын хучилтын хөрс нөөцлөх талбайтай; 7. Ландфиллын үйл ажиллагаанд шаардлагатай машин механизм, техник, тоног төхөөрөмжтэй; 8. Ландфиллын суурь нь шүүрэл нэвчихээс хамгаалсан доторлогоотой байх; 9. Хог хаягдал тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг цэвэрлэж, ариутгах нөхцлөөр хангагдсан байх; 10. Байгууламжид зөвшөөрөлгүй хүн, машин нэвтрэх, мал, амьтан орохоос хамгаалсан хашаатай байх; 11. Харуул, хамгаалалт, дохиоллын системтэй байх; 12. Хэмжих хэрэгсэл бүхий бүртгэл, хяналтын байртай байх; 13. Үйл ажиллагааны хяналтын систем/камер/-тэй байх; 14. Төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтцэд холбогдсон байх;
8	Онцгой нөхцөл	• Инженер геологийн дүгнэлтийг үндэслэл болгох; • Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй байх; • Тусгаарлах зурвас, хамгаалалтын бүсийг тогтоох; • Хог хаягдал ил задгай хийсэж тарахаас сэргийлэх урьдчилсан арга хэмжээг төлөвлөх;
9	Зураг, төсвийн иж бүрдэл	Зураг төслийн баримт бичгийн иж бүртэл: • Техникийн нөхцөлүүд /Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, цахилгаан хангамж, холбоо дохиолол/ • Барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын хяналт, дүгнэлт • Магадлалын нэгтгэсэн дүгнэлт Ажлын зургийн иж бүрдэл: • Батлагдсан загвар зураг • Батлагдсан ажлын зураг • Нүүр хуудас /батлагдсан/ • Орчны ерөнхий төлөвлөгөө, зай хэмжээ, өндөржилт, картограмм • Барилга, архитектор, технологийн зураг • Барилга бүтээц /Бүтээцийн тооцоо/ • Халаалт, агаар сэлгэлт • Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг • Цэвэр, бохир ус • Дотор холбоо, дохиолол • Батлагдсан ажлын зураг Гадна цахилгаан: • Гадна цахилгаан • Дулаан хангамж

		• Ус хангамж, ариутгах татуурга • Гадна холбоо, дохиолол • Барилгын нэгдсэн төсөв Зураг төсөлд тавигдах шаардлага: • Барилга, байгууламжийн гадна орчны тохижилтын элементүүдийг норм, дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх. • Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага, стандартын мөрдөх • Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийг WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх Батлагдсан зураг төсөл, загвар зураг болон ажлын зураг төсөл, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь – 1, хуулбар хувь – 3 хэвлэмэлээр, Pdf хэлбэрээр CD-нд бичиж 1 хувь хүлээлгэн өгнө.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Гадаргуугийн ус зайлуулах төлөвлөлтийг орчны нөхцөл байдалтай уялдуулж, талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх.
11	Зураг төсөв боловсруулах үе шат хугацаа	Ажлын зураг, төсөв нэг үе шаттай байна. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
12	Захиалагч байгууллага	Аймгийн Засаг даргын Тамгын газар
13	Ашиглагч байгууллага	Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар, Хот тохижуулах газар

ХЯНАСАН:
АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН

ЗӨВШИЛЦСӨН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ж.БАТ-ӨЛЗИЙ

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
БӨГӨӨД "ХББЗА" УТГЫН
ЗАХИРАЛ Ц.НЭМЭХБАЯР

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БУЯНХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН П.ЭНХСЭЛЭНГЭ